

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ...дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар хот

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.24, 3.1.25 дахь заалт:

"3.1.24."эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ" гэж хүн амын эрэлт хэрэгцээнд тулгуурлан төрөөс өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон үндсэн мэргэшлийн зарим нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг иргэн, гэр бүл, аж ахуйн нэгжийн оролцоотойгоор харьяалах нутаг дэвсгэрт байгаа хүн бүрт нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүй үзүүлэх үйл ажиллагааг;

3.1.25."эмнэлгийн урт хугацааны тусламж, үйлчилгээ" гэж сувилахуйн болон сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээг нэг сар болон түүнээс дээш хугацаанд үзүүлэх үйл ажиллагааг."

2/8 дугаар зүйлийн 8.1.25 дахь заалт, 8.4-8.9 дэх хэсэг:

"8.1.25.хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнийг эрт илрүүлэх үзлэгийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих.

8.4.Эрүүл мэндийн цахим бүртгэл, мэдээллийн сангийн өгөгдөл солилцох, хадгалах, хамгаалах, баяжуулах, ашиглах журмыг Засгийн газар батална.

8.5.Энэ хуулийн 8.1.25 дахь хэсэгт заасан үйл ажиллагааг зохион байгуулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8.6.Эрүүл мэндийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багцыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8.7.Эмнэлгийн урт хугацааны тусламж, үйлчилгээг боловсрол, нийгмийн халамжийн үйлчилгээтэй хослуулан үзүүлэх журам, жагсаалтыг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

8.8.Энэ хуулийн 16.16-д заасан төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг улс, бүсийн хэмжээнд бусад эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангах үйл ажиллагааг зохицуулах журам, тусламж, үйлчилгээний чиглэл, хамрах хүрээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8.9.Хүний амь насанд аюултай, хөгжлийн бэрхшээлд хүргэдэг ховор тохиолдох өвчин, эмгэгийг тодорхойлох аргачлалыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

3/ 16 дугаар зүйлийн 16.19-16.21 дэх хэсэг:

“16.19. Их сургуулийн эмнэлэг нь анагаах ухааны боловсрол олгох их сургуулийн түшиц, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг байна.

16.20.Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг нь Монголын уламжлалт анагаах ухааны үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

16.21.Энэ хуулийн 16.10-д заасан чиг үүрэгт хамаарах тусламж, үйлчилгээг нэг цэгээс хэд хэдэн хуулийн этгээд хамтран үзүүлж болно.”

4/ 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэг:

“33.3.Энэ хуулийн 33.1-д заасан нас барагчийн цогцсыг гэр бүл, асран хамгаалагч, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлд үндэслэн сургалт, судалгааны зорилгоор ашиглах журмыг Засгийн газар батална.”

5/ 44 дүгээр зүйлийн 44.1.6-44.1.7 дахь заалт:

“44.1.6.өөрийн байгууллагын ажилтныг урьдчилан сэргийлэх, өвчнийг эрт илрүүлэх үзлэг, шинжилгээнд энэ хуулийн 8.5-д заасан журмын дагуу товлосон хугацаанд хамруулах;

44.1.7.иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үйлчлүүлэгч, түүний гэр бүл, асран хамгаалагч, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр өвчний онош, дүгнэлт, оношилгоо, шинжилгээ, эмчилгээ, үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн талаар мэдээлэл өгөхийг эмнэлгийн мэргэжилтнээс шаардах, олон нийтэд мэдээлэхийг хориглоно.”

2 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хуульд дараах хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг:

“12.2.Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нь тухайн шатны Засаг даргатай зөвшилцөж, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгээс бусад харьяа эрүүл мэндийн байгууллагын даргыг хууль тогтоомжид заасны дагуу томилж, чөлөөлнө.”

2/16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэг, 16.7, 16.10, 16.16 дахь хэсэг:

“16.4.Сум, тосгоны эрүүл мэндийн төв нь хөдөөгийн хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх орон нутгийн өмчит хуулийн этгээд байх бөгөөд байршил, хүн амын төвлөрөл, осол гэмтлийн нөхцөл байдлаас хамааран яаралтай тусламж, үйлчилгээний болон багийн эмчийн салбартай байна.

16.7.Клиник нь үндсэн, эсхүл төрөлжсөн мэргэшлээр эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээг амбулаторийн болон өдрийн эмчилгээ хэлбэрээр эсхүл амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх байгууллага байна.

16.10.Нэгдсэн эмнэлэг нь 10 мянгаас доошгүй суурин хүн ам бүхий суманд эрүүл мэндийн анхан шатны болон 5-аас доошгүй үндсэн мэргэшлээр лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээг, аймгийн төв, дүүрэгт 7-оос доошгүй үндсэн мэргэшлээр лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх байгууллага байна. Аймгийн төв, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа нэгдсэн эмнэлэг нь хүн амын эрэлт хэрэгцээнд тулгуурлан зарим төрөлжсөн мэргэшлээр лавлагаа шатлалын нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг нэмэлтээр үзүүлж болно.

16.16.Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг нь улс, бүсийн хэмжээнд төрөлжсөн мэргэшлээр эмнэлгийн лавлагаа шатлалын мэргэшсэн тусламж, үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх, сургалт судалгаа, эрдэм шинжилгээний ажил эрхлэн, бусад эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил арга зүйгээр ханган ажиллах чиг үүрэг бүхий байгууллага байна."

3/ 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэг:

"17.4.Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, энэ хуулийн 16.10-д заасан суман дахь нэгдсэн эмнэлгээс бусад нэгдсэн эмнэлгийн удирдлагыг эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл, түүнээс томилсон гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ."

4/ 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэг:

"33.2.Энэ хуулийн 33.1-д заасан шинжилгээ болон амьд сорьцын эмгэг эд, эс судлалын шинжилгээ хийх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална."

3 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.9 дэх хэсгийн "29.2" гэснийг хассугай.

4 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ...дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар хот

**ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙГ
ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ